



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/21

Чойр

“Төрийн албан хаагчийн сургалт,  
ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг  
хангах” хөтөлбөрийг шинэчлэн  
батлах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг 1 дүгээр, “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Хөтөлбөрийн хүрээнд жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (М.Анхбаяр), шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг нягтлан бодогч (Б.Гүнжидмаа) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны  
өдрийн 1/24 дугаар тушаалын 1... –р  
хавсралт



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

### Нэг.Нийтлэг үндэслэл

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ гэж заасны дагуу тус хуулийн 57 дугаар зүйлд Төрийн албан хаагчийн цалин хөлс, 58 дугаар зүйлд Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг, 59 дүгээр зүйлд Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр, 60 дугаар зүйлд Төрийн албан хаагчид олгох тусламж, 61 дүгээр зүйлд Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, 62 дугаар зүйлд Төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг тус тус тусгасан байна.

**Өнөөгийн байдал:** Аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 59 орон тоотойгоор ажиллаж байна. Үүнээс УТ-3, ТТ-2, ТЗ- 31, ТҮ- 23, удирдах 13, гүйцэтгэх 35, туслах 11 албан хаагч байна.

Албан хаагчдын насны бүтцийг авч үзвэл 24 хүртэл насны 1, 25-34 хүртэл насны 12, 35-44 насны 4, 45-54 насны 3, 55-аас дээш насны 2 албан хаагч байгаагаас эмэгтэй 33, эрэгтэй 19 байна.

Нийт албан хаагчдын төрийн албанп ажилласан жилийг авч үзвэл 5 хүртэл жил ажиллаж байгаа 21, 6-10 жил ажиллаж байгаа 11, 11-15 жил ажилласан 9, 16-20 жил ажилласан 2, 20-25 жил ажилласан 4, 26- 30 жил ажилласан 1, 31-ээс дээш жил ажилласан 2 албан хаагч байна.

**Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт:** Тус судалгаанд нийт 30 албан хаагч оролцсон нь нийт албан хаагчдын 65.2 хувийг хамруулсан. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 3.3 хувь нь 25 хүртэл, 56.7 хувь нь 26-35, 23.3 хувь нь 36-46, 13.3 хувь нь 46-55, 3.3 хувь нь 56-аас дээш настай, 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй байна. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын ажил эрхлэлтийн байдлыг авч үзэхэд 76.6 хувь нь төрийн захиргааны, 20 хувь нь төрийн үйлчилгээний, 3.4 хувь нь төрийн тусгай албан тушаал эрхэлдэг бөгөөд 43.3 хувь нь 5 хүртэл жил, 26.7 хувь нь 6-10 жил, 30 хувь нь 10-аас дээш жил ажилласан байна.

Байгууллагын ажиллах орчин, өрөө тасалгааны нэхцөл байдал ажиллах шаардлага хангадаг уу гэсэн асуултад 23 албан хаагч буюу 76.7 хувь нь тийм, 7 буюу 23.3 хувь нь үгүй, ажлаа зохих ёсоор хийж гүйцэтгэхэд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан уу гэсэн асуултад 18 албан хаагч буюу 60.7 хувь нь тийм, 12 албан хаагч буюу 39.3 хувь нь үгүй, та ажил дээрээ өөрийн ур чадвараа бүрэн дайчлан ажиллах боломжтой юу гэсэн асуултад 21 албан хаагч буюу 67.9 хувь нь тийм, 19 албан хаагч буюу 32.1 хувь нь үгүй, таны мэдлэг, ур чадвараа хөгжүүлэхэд байгууллагын зүгээс анхаарч дэмждэг үү гэсэн асуултад 11 албан хаагч буюу 39.3 хувь нь тийм, 13 албан хаагч буюу 42.9 хувь нь заримдаа, 6 албан хаагч буюу 17.9 хувь нь үгүй, таны цалин урамшууллыг таны амьдралд хүрэлцдэг үү гэсэн асуултад 12 албан хаагч буюу 40 хувь нь тийм, 14 албан хаагч буюу 46.6 хувь нь заримдаа, 4 албан хаагч буюу 14.3 хувь нь огт үгүй, танай байгууллага таныг нийгмийн баталгаагаар хангадаг уу гэсэн асуултад 16 албан хаагч буюу 51.7 хувь нь тийм, 8 албан хаагч буюу 27.6 хувь нь заримдаа,

Судалгаанаас үзэхэд албан хаагчдын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, мэдлэг ур чадвараа хөгжүүлэхэд байгууллагын зүгээс анхаарч дэмжих нэн шаардлагатай байна.

### **Хоёр. Зорилго, зорилт**

**Зорилго:** Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар тогтвортой, иргэнд ээлтэй төрийн албыг төлөвшүүлэх.

**Зорилт:** Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

1. Төрийн албан хаагчдын цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх
2. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх
3. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах

### **Гурав. Арга хэмжээ**

#### **1 дүгээр зорилтын хүрээнд:**

1. Албан хаагчдын цалин хөлс, бусад нэмэгдлийг хуульд заасны дагуу олгох
2. Албан хаагчдад олгох хоол унааны нэмэгдлийг батлагдсан төсвийн дагуу олгох
3. Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийг нэмэгдүүлэх.
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнтэй уялдуулан үр дүнгийн урамшуулал олгох, цалин шатлалыг нэмэгдүүлэх.
5. Албан хаагчдын гүйцэтгэлийн үр дүн, гаргасан амжилт, бүтээлийг үнэлж шагнаж, урамшуулах

#### **2 дугаар зорилтын хүрээнд:**

1. Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.
2. Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж засвар үйлчилгээ хийх, тавилга, эд хогшил, техник, тоног төхөөрөмжөөр хангах
3. Төрийн албан хаагчдын нэмэлт баталгааг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх

#### **3 дугаар зорилтын хүрээнд:**

1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг байгууллагын дотоод журамд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах.
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор тэтгэмж, дэмжлэг, тусламж олгох.
3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
4. Эрүүл ажлын байрны орчныг бүрдүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх, ажил - амралтын тэнцвэртэй байдлыг хангах.

### **Дөрөв. Санхүүжилт**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын төсөв
2. Улс, орон нутгийн төсөв
3. Олон улсын төсөл, хөтөлбөр
4. Бусад

### **Тав: Хөтөлбөр хэрэгжих хугацаа**

Энэхүү хөтөлбөрийг 2022 – 2024 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

### **Зургаа. Удирдлага, зохион байгуулалт**

1. Хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах бөгөөд уг төлөвлөгөө нь аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт байна.


2. Хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хариуцаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга хяналт тавьж ажиллана.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хагас, бүтэн жилээр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

### Долоо. Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин			
			2022 он	2023 он	2024 он	2025 он
Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх						
1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	663 784 258.33 төгрөг буюу 95.5%	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу
2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл, мян.төг (Хоногт олгохоор тогтоосон дүн)	3.0	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу
Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх						
3.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	85.0	80 хувиас дээш	80 хувиас дээш	80 хувиас дээш	80 хувиас дээш
Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаах урьдчилан сэргийлэх						
4.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) – Төрөлжсөн болон багц шинжилгээ	1	1-ээс дээш	1-ээс дээш	1-ээс дээш	1-ээс дээш
5.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдыг хамруулсан байдал, хувь	100	90-ээс дээш	90-ээс дээш	90-ээс дээш	90-ээс дээш
6.	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал (сая.төг)	Батлагдсан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 21 300 000	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан төсвийн дагуу

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны  
өдрийн 01/01 дугаар тушаалын 2... –р  
хавсралт



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт “Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ”, 29 дүгээр зүйлийг 29.1 дэх хэсэгт “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна” гэж тус тус тусгасан.

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Сургалтын агуулга, хөтөлбөрийг, тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга”, 2 дугаар хавсралтаар “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг баталсан байна.

**Өнөөгийн байдал:** Аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 59 орон тоотойгоор ажиллаж байна. Үүнээс УТ-3, ТТ-2, ТЗ- 31, ТҮ- 23, удирдах 13, гүйцэтгэх 35, туслах 11 албан хаагч байна.

Албан хаагчдын насны бүтцийг авч үзвэл 24 хүртэл насны 1, 25-34 хүртэл насны 12, 35-44 насны 4, 45-54 насны 3, 55-аас дээш насны 2 албан хаагч байгаагаас эмэгтэй 33, эрэгтэй 19 байна.

Нийт албан хаагчдын төрийн албанп ажилласан жилийг авч үзвэл 5 хүртэл жил ажиллаж байгаа 21, 6-10 жил ажиллаж байгаа 11, 11-15 жил ажилласан 9, 16-20 жил ажилласан 2, 20-25 жил ажилласан 4, 26- 30 жил ажилласан 1, 31-ээс дээш жил ажилласан 2 албан хаагч байна.

**Сургалтын хэрэгцээ тодорхойлсон дүн:** Тус судалгаанд нийт 30 албан хаагч оролцсон нь нийт албан хаагчдын 65.2 хувийг хамруулсан.

Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 3.3 хувь нь 25 хүртэл, 56.7 хувь нь 26-35, 23.3 хувь нь 36-46, 13.3 хувь нь 46-55, 3.3 хувь нь 56-аас дээш настай, 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй байна. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын ажил эрхлэлтийн байдлыг авч үзэхэд 76.6 хувь нь төрийн захиргааны, 20 хувь нь төрийн үйлчилгээний, 3.4 хувь нь төрийн тусгай албан тушаал эрхэлдэг бөгөөд 43.3 хувь нь 5 хүртэл жил, 26.7 хувь нь 6-10 жил, 30 хувь нь 10-аас дээш жил ажилласан байна.

Сүүлийн 1 жилд албан хаагчдын сургалтад хамрагдсан байдлыг авч үзвэл Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 5, богино хугацааны мэргэшүүлэх сургалтад 8, хамрагдаагүй гэж хариулсан 11 албан хаагч байна.

Цаашид хамрагдах сургалтын талаар албан хаагчдаас дараах санал гарсан байна.

Үүнд:

- Төрийн албаны мэргэшүүлэх сургалтад хамрагдах – 8
- Ажиллаж байгаа албан тушаалын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдах – 6

- Магистрын сургалтад хамрагдах – 1
- Ёс зүй, харилцаа хандлага, сэтгэл судлал – 2
- Компьютер, гадаад хэл – 6
- Бусад чиглэлээр - 5

### **Хоёр. Зорилго, зорилт**

**Зорилго:** Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бүрдүүлэх.

**Зорилт:** Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг хуулийн хүрээнд Удирдлагын академийн богино, дунд хугацааны мэргэшүүлэх болон мэргэшүүлэх давтан, мэргэшүүлэх багц сургалтад хамруулан төрийн жинхэнэ албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх.

2. Байгууллагын дотоод сургалтын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, албан хаагчдыг ажлын байранд тасралтгүй суралцах орчин нөхцөлийг бүрдүүлж, чадавхжуулах.

3. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр туршлага судлуулах, сургалт, семинар, зөвлөгөөнд оролцуулах замаар мэдлэг, чадварыг дээшлүүлэх.

### **Гурав. Арга хэмжээ**

#### **1 дүгээр зорилтын хүрээнд:**

1. Удирдлагын академийн богино хугацааны сургалтад албан хаагчдыг ажил үүргийн дагуу хамруулах.

2. Төрийн захиргааны албан тушаалд анх томилогдсон албан хаагчдыг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдах.

3. Төрийн захиргааны албан хаагчдыг 3 жил тутамд мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамруулах.

4. Шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад хамруулах.

#### **2 дугаар зорилтын хүрээнд:**

1. Жил бүр дотоод сургалтын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж, ажлын байранд сургах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах.

2. Албан хаагчдын зайнаас суралцах орчин нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах.

3. Албан хаагчдыг ажлын байранд хөгжих боломжийг бүрдүүлж, анх томилогдсон албан хаагчдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

#### **3 дугаар зорилтын хүрээнд:**

1. Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, бакалавр, магистр, докторын сургалтад суралцахад дэмжлэг үзүүлэх.

2. Албан хаагчдыг гадаад, дотоодод туршлага судлуулах, зорилтот сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөнд оролцуулах.

### **Дөрөв. Санхүүжилт**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын төсөв
2. Улс, орон нутгийн төсөв
3. Олон улсын төсөл, хөтөлбөр
4. Бусад

### **Тав: Хөтөлбөр хэрэгжих хугацаа**

1. Энэхүү хөтөлбөрийг 2022 – 2025 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

### Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

1. Хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах бөгөөд уг төлөвлөгөө нь аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт байна.

2. Хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хариуцаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга хяналт тавьж ажиллана.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хагас, бүтэн жилээр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

### Долоо. Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин			
			2022 он	2023 он	2024 он	2025 он
<b>Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт</b>						
1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	26	28	30	32	34
1.1	Ажлын байран дахь сургалтын тоо	21	25	25	25	25
1.2	Мэргэшүүлэх сургалтын тоо	5	10	10	10	10
1.3	Туршлага солилцох арга хэмжээний тоо	0	2	2	2	2
1.4	Бусад	13	Зохион байгуулагдсан сургалтын тоогоор	Зохион байгуулагдсан сургалтын тоогоор	Зохион байгуулагдсан сургалтын тоогоор	Зохион байгуулагдсан сургалтын тоогоор
2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	48	48	Тухайн жилийн батлагдсан орон тоогоор	Тухайн жилийн батлагдсан орон тоогоор	Тухайн жилийн батлагдсан орон тоогоор
2.1	Эмэгтэй албан хаагчдын тоо	26	29	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор

2.2	Эрэгтэй албан хаагчдын тоо	22	19	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор
3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал /Нийт албан хаагчдад эзлэх хувь/:	100	90-ээс дээш хувь	90-ээс дээш хувь	90-ээс дээш хувь	90-ээс дээш хувь

**Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар гадаадад мэдлэг чадварыг дээшлүүлсэн байдал**

4	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	0	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор
4.1	Эмэгтэй албан хаагчдын тоо	0	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор
4.2	Эрэгтэй албан хаагчдын тоо	0	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор
4.3	Удирдах албан тушаалтан, тоо	0	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор
4.4	Гүйцэтгэх албан тушаалтан, тоо	0	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор	Хамрагдсан албан хаагчдын тоогоор
4.5	Гадаад сургалтад хамруулсан байдал, хувь	0	20-оос дээш	20-оос дээш	20-оос дээш	20-оос дээш

**Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт, хөдөлгөөн**

5.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан	1.1 сая	Тайлант оны гүйцэтгэлээр	Тайлант оны гүйцэтгэлээр	Тайлант оны гүйцэтгэлээр	Тайлант оны гүйцэтгэлээр
----	---	---------	--------------------------	--------------------------	--------------------------	--------------------------



	зардлын хэмжээ /сая.төгрөг/					
6.	Албан хаагчдын шилжилт, хөдөлгөөни й хувь	25.5%	15-аас доош	15-аас доош	15-аас доош	15-аас доош